

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Том. XXXIV (360)

2012

(125-137)

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ЯРУУ НАЙРГИЙН БҮТЭЭЛҮҮДИЙГ ДЭЛГЭЦИЙН
ДҮРС ШИЛЖҮҮЛЭХ АРГААР ТАЙЛБАРЛАХ НЬ

Д. Батжаргал *

Телевизийн план гэдэг дүрслэн үзүүлэх үндсэн арга юм. Ерөнхийд нь дүрсийг том /крупный план/, дунд /средний план/, ерөнхий /общий план/ байдлаар авдаг. Үүнийгээ том дүрс /ТД/, дунд дүрс /ДД/, ерөнхий дүрс /ЕД/ гэж ангилдаг. Том дүрсээр объектыг илүү тодруулж тодорхой шинжтэй болгодог. Дунд дүрс дүрслэлийг тодотгож зургий нь авч буй объектийн тухай мэдээллийг гүнзгийрүүлдэг. Дунд дүрс нь том дүрс, ерөнхий дүрс хоёрыг холбож өгдөг. Том дүрс дотроо хэд хэдэн янз байна. Аливаа хүн, объектод өөрийн өвөрмөц шинж чанар байдаг. Үүнийг тодруулахын тулд илүү нарийвчилсан том дүрс хэрэгтэй болдог.

Хүүхдийн яруу найргийн зарим бүтээлүүдийг он дарааллаар нь дүрсийн шилжилтээр тайлбарлан харуулъя.

№	Жишээ авсан бүтээлүүд	Ерөнхий дүрс /Общий план/ ЕД	Дунд дүрс /Средний план/ ДД	Том дүрс /Крупный план/ ТД	Дүрсийн шилжилт
1	Хэнз хурга /1933/	Миний хэнз хурга Магнай халзан зурвастай Мянган хонины дундаас Би хармагц танидаг	Дун цагаан үстэй Дуран хар нүдтэй Түмэн хонины дунд Түүнээс хөөрхөн амьтангүй	Өвөр дээр минь гараад Өхөөрдмөөр өхөөрдмөөр эрхэлдэг	ЕД-ДД- ТД
2	Хоёр ишиг /1933/	Хаврын наран шарлаад өвөлжөөний дотор дулаан бүлээн Хотын дунд хонь ямаа майлалдаад хоёр ишиг зэлийн хажууд мөргөлдөн наадна	Алаг ямааны ишиг холоос хурдан хурдан гүйн ирж мөргөн гэдрэг буцна Саарал ямааны ишиг дороо шилжин зогсон хүлээнэ	Эвэр нь ургаагүй боловч магнай дээр өчүүхэн товойжээ	ЕД-ДД- ТД-ТД- ДД

* МУИС-ийн МХСС-ийн багш, доктор

3	П.Хорлоо Туулай /1940/	Тал дундаа давхидаг би Тайган халтраас айдаг би Үндэс мэргэ амьдардаг би Өвгөн бүргэдээс айдаг би	Бөөрөнхий бор туулай би Бөг бөг шогшдог би	Бүлтгэр хар нүдэндээ Бөөн бөөн нулимстай би	ДД -ТД- ЕД-ДД- ЕД-ТД-
4	Сүхбаатар Ленинтэй уулзав /1944/	Алтан Кремлийн орой Алсаас тодхон гялалзаад	Хүндэт багш Ленин Залуу жанжны гарыг Чанга чанга атгаад	Ган болд сэлэмийг Ташаанд нь зүүж өглөө Гавьяаны улаан одонг Энгэрт нь хадаж өглөө	ЕД-ДД- ТД
5	Ч.Чимид Би Монгол хүн /1945/	Цэнхэр манан суунагласан Алсын бараа ширтээд	Үлээж байгаа салхи нь Үнсээд ч байгаа юм шиг Өршөөлт ээжийн минь гар Илээд ч байгаа юм шиг	Хосгүй баяр нулимс Хоёр нүдийг минь бүрхдэг	ЕД-ДД- ТД
6	Л.Бадарч Унага /1955/	Уулын жимээр Унага давхилаа Хадан дундуур Харайж гарлаа	Унага замдаа Ууттай юмтай Учран зогслоо Учры нь сонирхлоо	Үргэж бусгаж Үнэртэж хөдөлгөж Олон янзаар Оролдож үзлээ	ЕД-ДД- ТД
7	Жигмэд Тогмид хоёр /1958/	Жигмэд Тогмид хоёр Жимсэнд хамт явжээ Уулын модонд очоод Уралдаж түүхээр болжээ	Том савтай Тогмид нь Сүүлд нь гээд сүрджээ Жижиг савтай Жигмэд нь Түрүүлнэ гэж барджээ	Түүсээр байгаад Тогмидын Сав нь дүүрээд иржээ Идсээр байгаад Жигмэдийн Гэдэс нь цадаад иржээ.	ЕД- ДД- ТД
8	“Аймхай бор хүү Хашин хар морь” найраглал	Овоот өндрийн чулуун замаар Оч үсэргэж хурдлан давхив	Өндөр эргэтэй өргөн жалгаар Өдтэй юм шиг харайн дүүлэв		
9	Аранзал зээрд	Талаар талаар Ташуур өгөн Ташуур өгөн Довтолгов	Замаар замаар Тоос босгон Тоос босгон Хурдалгав	Хатан дэлхийг Дөрвөн туурай Дөрвөн туурай Бөмбөрдөнө	ЕД-ДД- ТД

10	Мөндөр	Тайгын нуруунд бөмбөрсөн Танан цагаан мөндөр сөн	Урцан дээгүүр бөмбөрсөн Шүрэн цагаан мөндөр сөн	Цааны нуруунд бөмбөрсөн Цалин цагаан мөндөр сөн Усан дээгүүр бөмбөрсөн Уран цагаан мөндөр сөн	ЕД- ТД	ДД-
11	Мөлхөө ангийнхан	Энгүй уудам Сүхбаатарын талбайд Энхийн жагсаал жигдэрсэн байлаа	Эрээн алаг хивсэн дээгүүр Эхний жагсаал яралзаад ирлээ	Бунхант индрийн өмнөх зайгаар Булчингаа гялалзуулан мөлхөж гарлаа	ЕД-ДД- ТД	
12	Дүүжин даажин /1990 оноос хойш/	Жингийн цагаан туухай шиг Хоёр хөөрхөн охин Жинлүүрийн царан таваг шиг Хормойгоо дэрвийлгэн Дүүжин даажин Дүүлэн наадна...	Эрвээхэйн хоёр далавч шиг Нисэж бууж харагдана Эмээлийн хоёр бүүрэг шиг Ихэр юм шиг үзэгдэнэ	Тэнгэр газар инээж Тэр хоёр баясна Тэртээх энэтээх уулс Тэргүүн дээгүүр нь өндөлзөнө....	ЕД-ДД- ТД	

ХҮСНЭГТЭЭР ЖИШЭЭ АВСАН ШҮЛГҮҮДИЙН ТАЙЛБАР

Д.Нацагдоржийн “Хэнз хурга” шүлэгт кино дэлгэцийн ойрын зай /крупный план/, дундын зай /средний план/, алсын зай /общий план/ гэдэг гурван зарчмыг баримтлан шүлэглэсэн нь уншмагц мэдэгдэнэ.

“...Миний хэнз хурга

Магнай халзан зурвастай

Мянган хонины дундаас

Би хармагц танидаг” гэж магнайн зурвас ялгарах төдий зайнаас зураглан гаргаад улмаар ойртуулан авчирч

“...Дун цагаан үстэй

Дуран хар нүдтэй

Түмэн хонины дунд

Түүнээс хөөрхөн амьтангүй”

хэмээн “дуран хар нүд” үзэгдэх дундын зайнаас

“...Өвөр дээр минь гараад

Өхөөрдмөөр өхөөрдмөөр эрхэлдэг” гэж бүр дэргэд өвөр дээр

байгаагаар гаргасан нь онцгой сонин зохиомж болжээ. Одоо “Хоёр ишиг” шүлгийг авч үзье. Хаврын хот айл алсаас харагдаж бүлээн дулаан хашаа хороонд тоглож байгаа хурга ишиг үрүү аажмаар ойртоно.

“...Хаврын наран шарлаад өвөлжөөний дотор дулаан бүлээн

Хотын дунд хонь ямаа майлалдаад

Хоёр ишиг зэлийн хажууд мөргөлдөн наадна”

Тогтуун сайхан наран тавтайяа ээж, бүлээн дулаан илч нь өвөлжөөнд мэдрэгдэж байгааг харагдуулахын тулд ийнхүү холоос эхэлж байна.

“...Алаг ямааны ишиг холоос хурдан хурдан гүйн ирж мөргөн гэдрэг буцна


Саарал ямааны ишиг дороо шилжин зогсон хүлээнэ”

Дуран хотон дотор ороод ирсэн хоёр ишгэн дээр тогтож байна. Санал асуулгад оролцсон оюутнууд энэхүү шүлгийг дүрслэлийн хувьд сайшааж уран санаа, хэмнэл талаас шүүмжилсэн байна. Зарим нь утга зүйн алдаатай, хүүхдийн сэтгэхүй хэл ярианд хүнд, уран санаа, хошин аяс алга, зүгээр л хоёр ишиг мөргөлдсөн, эхээ хөхсөн тухай бичсэн, өгүүллэг шиг урт мөрөөр үргэлжлүүлэн өгүүлсэн гэх мэтээр бичсэн байхад хамгийн дүрслэл сайтай сайн шүлэг гэж бичсэн оюутнууд *“Малчны хотонд очсон юм шиг сэтгэгдэл төрсөн, магнай дээрээ өчүүхэн товойсон ишиг харагдаж байна, хаврын өдрийн дүр зураг өвөлжөөний байдлыг нүдэнд харагдахуйц бичсэн”* хэмээжээ. Дүрслэл сайтай байгаа нь план сэлгэж харуулсанд оршино.

Ер нь алсын дүрс үзэгчдэд үйл явдал болж буй орчныг бүхэлд нь харж хүмүүс, юм үзэгдлийн орон зайг ойлгоход тус болдог. Гэтэл юмыг дандаа алсаас авсан дүрсээр үзүүлээд байвал үзэгч сэтгэл дундуур үлдэнэ. Учир нь тэд үйл явдлын нарийн ширийнийг харахсан гэж хүснэ. Үйл явдлын нарийн ширийнийг тодруулан дандаа том дүрсээр үзүүлээд байвал үзэгчийг хэтэрхий албадлагын байдалд оруулж эргэлзээ төрүүлнэ. Дандаа дунд дүрсээр харуулбал бас их уйтгарлах болно. Тиймээс план сэлгэлт хэрэгтэй болдог. Шүлэгт харагдаж байгаа дүрс ч мөн адил.

Телевизийн хувьд хамгийн амин сүнс нь хөдөлгөөнтэй дүрс. Хөдөлгөөнтэй дүрсийг дэлгэцэнд гаргахын тулд дэлгэцийн хэл ашигладаг. Дэлгэцийн хэлийг телевиз кино урлагаас зээлдэж авсан гэдэг. Дэлгэцийн хэлийн үндсэн ойлголт нь кадр буюу хүрээлсэн дүрс, план буюу тогтсон дүрс гэж хоёр янз бий. *“Тухайн мөчид тодорхой хүрээнд харагдаж байгаа орон зайн нэг хэсгийг кадр гэнэ”*¹ оросын сэтгүүл зүйн судлаач тайлбарласан байна. Телевизэд хөдөлгөөн их чухал байдаг шиг хүүхдийн яруу найрагт бас тийм юм. Эрдэмтэн зохиолчийн нэгэн шүлгийг одоо ажиглая.

П.Хорлоогийн *“Туулай”* шүлэг туулайн явдлаасаа эхэлж байгаа болохоор дунд дүрсээр эхлээд *“Бүлтээр хар нүдэндээ бөөн бөөн нулимстай би”* гэж том дүрс үрүү шилжин, ерөнхий дүрсээ дараа нь өгчээ. Дүрсийн дарааллаар зурагжуулж үзүүлье.



*“...Бөөрөнхий бор туулай би
Бөг бөг шогшидог би”*

¹ Кузнецов. Г.В (2002), *Телевизионная журналистика*, стр 117 Москва.,



*“...Бүлтгэр хар нүдэндээ
Бөөн бөөн нулимстай би”*



*“...Үндэс мэргэ амьдардаг би
Өвгөн бүргэдээс айдаг би”*

Шүлгийн эхний зургаан мөр нь яг ийнхүү гурван планыг сэлгүүлэн өгсөн байна. Дараагийн гурван хос мөр нь “хоргодож бутандаа хэвтдэг би, хурганы хүүхдээс зугтдаг би” гэж ДУНД, “тал дундаа давхидаг би, тайган халтраас айдаг би” гэж ЕРӨНХИЙ, “дэвхэрч дэгдэж явдаг би, дэлдэн хоёр чихтэй би” гэж ТОМ дүрс байдлаар сэлгүүлэн дүрсэлсэн байна.

Цуваа эвлүүлэгт дүрсийг ерөнхийгөөс дунд уруу дундаас том руу /ЕД-ДД-ТД/ гэсэн гол дарааллаар угсарна. Томоос том дүрс үрүү шилжих дараалал бас зөв байдаг. Харин дундаас дунд уруу /ДД-ДД/, ерөнхийгөөс ерөнхий үрүү /ЕД-ЕД/ шилжих шилжилтийг эвлэхгүй дараалал гэж телевизийн сэтгүүл зүйд үздэг. Хэдийгээр

телевизийн цуваа эвлүүлгийн “хуулиар” бичээгүй хэдий ч оновчтой болсон үндэс нь дүрсийг зөв сэлгүүлсэнд оршино.

Үзэгдэхүйц байна гэдэг хүүхдийн яруу найргийн бас нэг онцлог. Хүүхэд хөлд хөлд орохоос өмнө хамгийн түрүүн харааны мэдрэхүй хөгждөг. Төрөөд сар ч бололгүй аав ээжээ таньж хурц тод өнгийг түрүүлж хардаг. Тиймээс хүүхдийн тоглоом цэцэг мэт хурц содон өнгөтэй байх нь бий. Зохиолч П.Хорлоогийн 16 хэсэгтэй найраглалд жанжин Д.Сүхбаатарын дүрийг тод томруун гаргаж хүүхдүүдэд хувьсгалын үйл хэргийг ойлгомжтой тусган үзүүлжээ. Найраглалын талаар эрдэмтэн Ч.Аръяасүрэн “Сүхбаатарын бага нас, хувьсгалын үйл хэргийн төлөө тэмцсэн, амьдралын нь алдарт замналаас намтарчлан өгүүлж, өсвөрийн уншигчдыг Сүхбаатарын үйл хэрэгт үнэнч байхыг уриалан дууджээ... Хэзээ ч асар сайхан үлгэр дууриал байдаг их хүний амьдрал үйл ажиллагаа хүүхэд багачуудын сэтгэлийг сэргээж, урам зоригийг бадраадаг билээ”² гэж хэлсэн байдаг. Ялангуяа сургуулийн үдэшлэг, уулзалт, концертод хүүхдүүд цээжлэн олонтаа уншдаг “Сүхбаатар Ленинтэй уулзав” хэсгийн “Алсаас тодхон гялалзсан Алтан Кремлийн орой” /ЕД/, “Хүндэт багш Ленин залуу жанжны гарыг чанга чанга атгаад” /ДД/, “Ташаанд нь зүүж өгсөн ганболд сэлэм, энгэрт нь хадаж өгсөн гавьяаны одон” /ТД/ зэрэг тодорхой дүрслэл их байгаа нь хүүхэд цээжлэхэд дөт, тэдний сэтгэхүйд нь ойр байна.

Сурах бичигт олонтаа орсон Ч.Чимидийн “Би монгол хүн” шүлэгт нүд алдам уудам эх нутгаа харж сэтгэл бахдан зогсож байгаа хүнийг мөнхүү дэлгэцийн гурван планаар харан дүрсэлсэн байна. “Оросууд хэсэгчилсэн дүрсийг найм ангилдаг, харин америкууд арав ангилдаг”³ юм байна. Үүнд:

Онцгой том дүрс:	Хүний нүд, гар хуруу гэх мэтийг тодотгож үзүүлдэг томруун дүрс
Хэт том дүрс:	Хүний нүүрийг тодруулан үзүүлдэг томруун дүрс
Хөрөг том дүрс:	Хүний толгойг тодруулан үзүүлдэг томруун дүрс
Том дүрс:	Хүний толгой мөрийг оролцуулан үзүүлдэг томруун дүрс
Дунд том дүрс:	Хүний цээжийг оролцуулан үзүүлдэг том дүрс
Дунд дүрс 1:	Хүнийг бүсэлхий хүртэл үзүүлдэг дунд дүрс
Дунд дүрс 2:	Хүнийг өвдөг хүртэл үзүүлдэг дунд дүрс
Дунд ерөнхий дүрс:	Хүнийг бүтнээр нь, гэхдээ дээр дороосоо бага зэрэг зай авч үзүүлсэн дүрс
Ерөнхий дүрс:	Хүнийг эргэн тойронтой нь үзүүлсэн ерөнхий дүрс
Алсын дүрс:	Хүнийг орчинтой нь үйл явдлын дунд харуулсан алсын дүрс. Алсын дүрс үйл явдлын талаарх ерөнхий төсөөлөл бий болгодог” ⁴ гэж телевизийн сэтгүүл зүйн сурах бичигт өгүүлжээ.

Тэгвэл “Би Монгол хүн” шүлгийн,
“...Цэнхэр манан суунагласан
Алсын бараа ширтээд
Цэнхэр сайхан нутгаа

² Аръяасүрэн, Ч (1980) *Орчин үеийн монголын хүүхдийн зохиол*, 53-54 дүгээр тал, Улаанбаатар.,

³ Gerald Millerson (2004) *Television production*, page 10, BBC.,

⁴ Наранжаргал, Х (2006) *Телевизийн сэтгүүл зүй*, 40 дүгээр тал, Улаанбаатар.,

*Сэтгэл бахдан харахад
Үлээж байгаа салхи нь
Үнэсээд ч байгаа юм шиг
Өршөөлт ээжийн минь гар
Илээд ч байгаа юм шиг
Энэрэнгүй сайхан санагдахад
Элэг зүрх минь догдолж
Хосгүй баярын нулимс*

Хоёр нүдийг минь бүрхдэг”⁵ гэсэн хэсэгт эхний дөрвөн мөрөнд манан суунагласан монгол эх орны уудам сайхан нутгийн ерөнхий дүрсийг харуулж, дараагийн дөрвөн мөрөнд эх нутгийнхаа салхинд илбүүлэн зогсож байгаа монгол хүний дүр төрхийг дунд дүрсээр илэрхийлж энгүй сайхан нутгаа бахдан нулимс цийлэлзүүлэн зогсоо нүүр царайг тод томруунаар үзүүлсэн байна.

Яруу найрагч Б.Явуухулан “Ч.Чимидийн уран бүтээлийн сэдвийн хүрээ өргөжиж, орчин үеэ дуулж, шүлэглэх арга барилд нь шинэ зүйл гарсан. Ер нь Ч.Чимэд оюуны өндөр соёлтой хүн гэдгээ ч шүлэг зохиолдоо тод тусгах болсон юм”⁶ гэж түүний шүлэг зохиолын цар хэмжээг нэгэн үеийн уран бүтээлч нь үнэлсэн байна. Шинэлэг сонсогдоод, оюуны өндөр чадвартай уран бүтээлч харуулж байгаагийн нэгэн нууц нь уран дүрслэлийн план сэлгүүлэх арга байж болно.

Л.Бадарчийн “Унага” хүүхдийн сэтгэл татсан сайн шүлэг.

*“...Уулын жимээр
Унага давхлаа
Хадан дундуур
Харайж гарлаа”*

Холоос ийн дүрсэлнэ. Уулын жим харуулахын тулд өндөр нам ч бай уул дүрслэгдэнэ. Алсаас харагдуулах “хэрэг” гарна. Уулыг яавч ойроос гаргаж үл болно.

*“..Унага замдаа
Ууттай юмтай
Учран зогслоо
Учры нь сонирхлоо”*

Зам дээр ууттай юм байгааг харуулахын тулд дуран бас л холоос үзүүлнэ. Гэхдээ уул тусгаж байснаас ойртоно. Унага ууттай зүйлд тулаад очлоо. Хүүхдийн сэтгэлд ч ууттай тэр юм юу бол нээж үзэхсэн гэсэл хүсэл төрнө. Унагатай цуг дуран дундын зайд дөхөөд очлоо.

*“...Үргэж бусгаж
Үнэртэж хөдөлгөж
Олон янзаар
Оролдож үзлээ”*

Унаганы дэв давхийсэн хурдан хөдөлгөөн, нялх амьтны сониуч зан, гайхах хачирхах авир энэ бадагт гарч байна. Унаганы хошуу, ууттай юмны дүрс том дэлгэцэд тод харагдаж байна.

⁵ Хүүхдийн зохиолын дээжис (1971), 56 дугаар тал, Улаанбаатар.,

⁶ Явуухулан.Б (1990), 1960-аад оны эхний хагасын манай үеийн яруу найраг II боть, 39 дүгээр тал, Улаанбаатар.,

Судлаач Д.Оюунбадрах “Унаганы үргээж, бусгаж, үнэртээж, хөдөлгөж олон янзаар оролдож байгаа зэрэгт цовоо сэргэлэн хүүхдийн томоогүй, зүггүй байдал туссан мэт сэтгэгдэнэ. Ардын аман зохиолоос чухамхүү хүүхдийн байдалд тохируулан билигтэй сайхан боловсруулсан нь даруй Л.Бадарч агсны “Унага” гэдэг энэ зохиол болно. Энэ зөвхөн шүлэг болсон төдий биш, чухамхүү яруу найраг, тэр дундаа хүүхдэд зориулсан яруу найраг болсон байна”⁷ гэжээ. Зөв планаар дүрсэлсний хүчинд судлаачаас ийнхүү өндөр үнэлэлт авахад хүргэжээ. Хэл найруулгын хувьд өндөр чадвартай сайн бүтээснийг өмнөх бүлэгт дурдсан болно.

“...Жигмэд Тогмид хоёр
Жимсэнд хамт явжээ
Уулын модонд очоод
Уралдаж түүхээр болжээ”

Үеийн хоёр хүү бортого сав бариад зуны сүүл намрын эхэн сарын үед жимсэнд явж байна. Цаана нь цэцэг, жимстэй сайхан уул харагдана. Уралдаж түүх болсныг тэдний яриа, өгүүлэгчийн тайлбараас мэдэж болно.

“...Том савтай Тогмид нь
Сүүлдэнэ гээд сүрдэжээ
Жижиг савтай Жигмэд нь
Түрүүлнэ гэж бардэжээ”

Жимс түүх болтол асуудал гарлаа. Хоёр хүүгийн сав харилцан адилгүй. Гэтэл аль аль нь саваа дүүргэх ёстой байдаг. Тэгэж байж л түрүүлнэ. Энд ямар ч уул ус алсын дүрс үзүүлэх шаардлагагүй. Жимсний бутны дэргэд очсон хоёр хүү л дэлгэц дотор байна. Том савтай Тогмид саваа барин сэтгэл дундуур байхад жижиг савтай Жигмэд түрүүлнэ гэж хөөрөн дэвэрч онгирч байгаа зураг. Биеийн хөдөлгөөнөөр илэрч байгаа хүүхдийн хөөр баярыг уншигч төсөөлж болно.

“...Түүсээр байгаад Тогмидын
Сав нь дүүрээд иржээ
Идсээр байгаад Жигмэдийн
Гэдэс нь цадаад иржээ”

Жимс дүүрсэн сав, гэдэс нь цадсан хүүхэд хоёрыг холоос үзүүлэх боломж бага. Хамгийн ойр зайнаас харуулна. Дундын зайнаас үзүүлэх ч бас амаргүй. Цатгалан хүүхэд гэдсээ дардаг юм уу, эсвэл жимс хараад дургүйцэх байдал гаргаж байгааг нүүр царайны хувирлаар үзүүлэхэд зайлшгүй том дүрс хэрэг болно. “Д.Содномдоржийн “Жигмэд Тогмид хоёр” дуу нь хүүхдийн дотоод сэтгэлд орж, гэнэн хонгор зан болон залхуурахын хор уршгийг номлох талаас биш, дүрээр, үйл явдлаар илэрхийлж гаргаснаараа гандан бууршгүй бүтээл болсон”⁸ учир үе үеийн багачуудын дуулах дуртай дууны нэг болж чадсан байна.

Дүрслэл /description/ гэдэг харагдахгүй байгаа зүйлийг оновчтой тод харагдуулах эрдэм. Сэтгүүл зүйн онолд бичлэгийн зарим нэгэн төрлийн гол элемент нь болдог. “Дүрсэлсэн сурвалжлагын амин сүнс нь агуулгадаа тохирсон дүрслэл хийх явдал юм. Дүрслэл хийхийн өмнө дүрслэх газраа очиж ажиглалт хий. Нүдээ аниад санаандаа зурагла. Радиод чиглүүлэх үгс бичдэг бол сонинд логик дарааллаа санаандаа

⁷ Монголын хүүхдийн уран зохиол 1 боть, (2007), 50-52 дугаар тал, Улаанбаатар.,

⁸ Содномдорж. Д (2003) ХХ зууны монгол зохиолчид, 29 дүгээр тал, Улаанбаатар.,

тогт. Байр сонголтын хувьд өөрийн нүдээ телевизийн дуран гэж бодон дүрслэл хийхдээ,

-хажуунаас

-дээрээс доош

-алслуулан татах

-зогсолт /пауз авах/ гэх мэтээр уншигчдын нүдэнд харагдахуйц зураглал өгч болно”⁹ Шүлэг ч мөнхүү уншигчдад дүрслэл бий болгох зорилготой.

Содномдоржийн туульсын томоохон бүтээлээс ч дэлгэцийн план сэлгэх аргаар бичсэн жишээ олж болно.

“Аймхай бор хүү, хашин хар морь” найраглалд адууны сүүлд явдаг хашин хар морь, өчүүхэн зүйлээс ч болов айж байдаг жаахан бор хүү хоёр эх орон дуудсан хэрэгтэй цаг болоход ямар их зориг тэвчээр хурд хүч гаргаж байгааг үзүүлдэг. Суман мөндөр дундуур ар талд хэл хүргэх болтол хашигнаж явдаг морины “хумбан дөрвөн туурайнд нь газрын хөрс эргэсээр, хулан хоёр чихэнд нь сансрын салхи исгэрсээр” жигүүр ургасан мэт довтолгож байгааг

“...Овоот толгойн чулуун замаар

Оч үсэргэн хурдлан давхив

Өндөр эрэгтэй өргөн жалгаар

Өдтэй юм шиг харайн дүүлэв

Хүүгсэн салхи өврөөр дүүрч

Хүүгийн дээлийг хөөргөдөн хийлэв

Хоёр нүднээс нь нулимс асгарч

Хоолой нь хатан сэврэгнэн аргав”¹⁰

Жишээ авсан эхний хоёр мөрөнд овоот толгой бүтнээр харагдах тул алсын зай шаардана. Нэг үгээр хэлбэл холоос харж байна. Оч үсэргэх нь өдөр тэр бүр харагдахгүй. Хоёр дахь хоёр мөрөнд дуран ойртон ирлээ. Жалга байгаа болохоор нэлээд дөхөж очлоо гэсэн үг. Жалган дээгүүр харайн дүүлж байгаа морийг харагдуулахын тулд их ойртох болно. Гэхдээ хэт ойртвол бас ямар хурдтай ирээд яаж харайж байгаа нь мэдэгдэхээ болино. Харайж байгаа нисэлтийг дундын зайнаас авах болно. Гурав дахь хоёр мөрөнд хүүхдийн өвөр салхинд хийлэгдэн бөмбийж харагдана. Морины зоон дээр дарцаглаж яваа хүүгийн цээжин биеийг дуран бүхэлд нь харууллаа. Том дүрсэд шилжлээ гэсэн үг. Дөрөв дэх хоёр мөрөнд сандарч хүүгийн нүүр дэлгэц дүүрнэ. Хүүхдийн даалин хацар, нулимстай нүд... Хамгийн тод томруун дүрслэл. Ерөнхий болон дундын зайнаас үл харагдах дүрслэл энэ. Нулимсаа гараараа болон ханцуйгаараа арчиж байгаа бол дундын зайнаас анзаарагдаж мэднэ. Гэхдээ исгэрсэн суман дундуур давхиж яваа хүүхэд нулимсаа арчих зав ухаан байхгүй.

Ер нь Содномдорж хүүхдийн том хэлбэрийн бүтээл бий болгоход тодорхой хувь нэмэр оруулсан хүн. “Түүний “Норовын намтар”, “Тахир тав махир хоёр”, “Дугаар ангийн Дугар”, “Навсайдамба ба түүний нөхөд” зэрэг томоохон найраглал, шүлэглэсэн тууж нь хүүхдийн утга зохиолд яруу найргийн том хэлбэрийг буй болгоход хамгийн мэдэгдэхүйц хувь нэмэр”¹¹ оруулжээ гэж эрдэмтэн зохиолч Л.Түдэв үнэлсэн буй.

⁹ Батжаргал. Д (2008) Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар 26 дугаар тал, Улаанбаатар.,

¹⁰ Хүүхдийн уран зохиолын дээж (1981), 69 дүгээр тал, Улаанбаатар.,

¹¹ Түдэв.Л (1998), “Түмэн хүүхдийн эчнээ багш” өгүүлэл. “Содномдорж түүний нөхөд” ном. 5 дугаар тал, Улаанбаатар.,

Найраглал дотор нь ч сувд шигтгээ мэт тодорхой дүрслэлүүд байгаа нь бүтээлдээ чамбай ханддагийн нотолгоо.

Ж.Дашдондогийн “Аранзал зээрд”, “Мөндөр” шүлэг мөн л дэлгэцийн план ашиглахын үлгэрийг үзүүлсэн гэж хэлж болно.

“...Талаар талаар

Ташуур өгөн

Ташуур өгөн

Довтолгов /Хол явж байна/

Замаар замаар

Тоос босгон

Тоос босгон

Хурдалгав /ойртоод дундын зайд шилжлээ/

Хатан дэлхийг

Дөрвөн туурай

Дөрвөн туурай

Бөмбөрдөнө /маш их ойроос том дүрсээр харж байна/”

Энэ шүлгийг уран чадвар талаас нь олон судлаач тайлбарласан. Явдал хөдөлгөөн, хэмнэл талаас нь их үнэлсэн. Хүний амьдралын жам ёсыг өгүүлсэн ч гэж гүнзгий боддог үзлийн хажуугаар “Аранзал зээрд” шүлэг нь морины явдлаар алхсанаа шогшиж, шогшсоноо ергүүлж, ергүүлснээ хатируулж, хатируулснаа цогцуулж, цогцуулснаа давхиж буй үйл хөдлөлийн дүрслэлээр шүлгийн уран яруу айзмын өрнөлт өсөлтийг үзүүлж, эргээгээд давхиагаас хурдаа бууран бууруулсаар алхахад хүргэж урласан нь монгол уран найруулахын үлгэр болсон гэж үзэж болно.

Морины явдлыг ахиулах маягаар бичсэн “Аранзал зээрд” шүлэгт газар орны үлдэн хоцорч байгааг давтах маягаар дүрсэлж төгсгөлдөө морины явдал удааширсаныг давтан өгүүлжээ. Шүлгийг уншихад морин дээр давхиж яваа мэт сэтгэгдэл төрж байна гэж санал асуулгад оролцсон хүүхдүүд дүрслэл талыг нь онцолсон юм.

“...Тайгын нуруунд бөмбөрсөн

Танан цагаан мөндөр сөн”

Хад асга, ой хөвч, харгана бургасаар битүү бүрхсэн, үелсэн их тайгад том том ширхэгтэй мөндөр орж байгаа зураг нүднээ тусна. Тайгын тэнгэрийн араншин энэ.

“...Урцан дээгүүр бөмбөрсөн

Уран цагаан мөндөр сөн”

Дундын зайд шилжлээ. Тайгын оройд хавцал суганд, модтой бэлд хаа ч хамаагүй мод зангидан эсгий, хөдөс, ангийн арьс, бугын шир тэргүүтнээр бүтээсэн гурвалжин гурвалжин урц... Бөөрөнхий бөөрөнхий үрлэн мөндөр шовх оройтой эгц шахам урцны гадаргуу дээгүүр бөмбөрөлдөнө.

“...Усан дээгүүр бөмбөрсөн

Шүрэн цагаан мөндөрсөн”

Тайгын уйтан хавцал дундуур цовхчин урсах гол мөрний мандал дэлгэц дүүрнэ. Мөндөр чулуу шиг дорхноо живэхгүй, бас цас шиг агшин зуур хайлахгүй. Мөндрийн ширхгүүд усны мандалд жижиг жижиг долгио үүсгэн нэгэн хэсэг хайлахгүй хөвнө. Мөндөр нэлэнхүйдээ мөндөрт хучигдана. “Дүрслэн бодох нь анхны гишгүүр хийгээд бүх яруу найргийн үндэс юм. Яруу найрагч хүн ямагт дүрслэн бодохынхоо уудам зайд тэнээж явдаг” Гарсиа Лорка хэлсэн байдаг.

Дүрслэл сайтай шүлгүүд хүүхдийн сэтгэлийг байлдан дагуулна. Дээр нь хөдөлгөөн бүр их чухлыг өмнөх бүлэгт өгүүлсэн. Хөдөлгөөнийг гурван планаар үзүүлэх нь уншигчдад сонирхолтой хүчтэй байдгийг Д.Даваанямын “Мөлхөө ангийнхан” шүлгээс харж болно.

“...Энгүй уудам Сүхбаатарын талбайд

Энхийн жагсаал жигдэрсэн байлаа”

Д.Даваанямын “Мөлхөө ангийнхан”, “Өлгийтэй ангийнхан” шүлгүүд нь судлаач Д.Өлзийбаярын хэлснээр “өлгийгүй” ангийнханд зориулсан зохиолд хэт дасчихсан уншигчдад, хүүхдийн утга зохиолд цоо шинэ сэрхийлт болсон¹² нь хүүхдийн утга зохиол 1960-аад оноос хойш амжилттай хөгжиж буйг үнэлсэн судлаачдын үнэлгээ байна.

“Дүрслэн бодохын жинхэнэ үр хөврөл бол зөн билгийн агшин зуур зурсхийх очис болоод урьдаас мэдрэх урт хугацааны түгшүүрээс бадран гарсан зүйрлэл юм. Гэхдээ дүрслэн бодох нь бодит байдлаар хязгаарлагддаг бөгөөд дүрслэн бодоход эд юмс, хараа бараа, тоо, гариг, одод хэрэгтэйн дээр тэр бүгдийн учир шалтгааны холбоо чухал байдаг”¹³

Хүүхдийн шүлэгт гэсэн хөдөлгөөнтэй ч гэсэн нэгэн хэвийн дүрс уйтгартай байдалтай байна. Г.Ганболдын “Бөмбөө” шүлэгт,

“...Бөмбөөгөө үүрээд явлаа

Бөндгөр хомоол бөөндөөн

Савараа бариад алхлаа

Сармай аргал зөндөөн

Хамар дагаад харлаа

Хар хомоол бөөндөөн

Хөтөл даваад явлаа

Хөх аргал зөндөөн

Өөд уруугүй өгслөө

Өнжмөл хомоол ихээ

Холхон гараад түүлээ

Халтар аргал элбэг ээ”

Хөдөөний ажилсаг монгол хүүхэд аргал түүж байгаа үйл явдлыг үзүүлсэн боловч дунд дүрс /ДД/-ээр үзүүлсэн болохоор сонирхолтой биш байна. Дээрхи шүлгүүдийн адилаар аргал түүх ажил үйлийг холдуулж ойртуулж томруулж жижигрүүлж үзүүлсэн бол сонирхолтой сайхан шүлэг болохсон. Энэ шүлэгт алслалт том дүрс хоёр дутаад байна. “Юмс ажиглагчаас холдох тусам жижгээрч, өнгө нь өөрчлөгдөж харагдах үзэгдлийг алслалт гэнэ. Энэ үзэгдлийг эртний Грек, Хятад зэрэг оронд 2500 жилийн тэртээ мэддэг байсан боловч олон зуун жилийн дараа Италид алслалтын хуулийг зураачид нээжээ. Алслалтын хууль нь зургийн хавтгайд өргөн уудам орон зайг багтаан үзүүлэх боломж олгодоггоороо онцлог юм.”¹⁴ Үүнийг анзаараагүй олон яруу найрагч алт шиг санаагаа үгийн цуглуулга болгосон тал бий.

¹² Давааням.Д (2003), “ХХ зууны монгол зохиолчид” цуврал, 21 дүгээр тал, Улаанбаатар.,

¹³ Цэдэндорж.М (1984), Уран зохиолын тухай бодол, 71-72 дугаар тал, Улаанбаатар.,

¹⁴ Дүрслэх урлагийн нэр томъёоны тайлбар толь www.read.mn цахим хуудас

Одоо ижил нэртэй хоёр шүлгийг жишиж үзүүлье.

бадаг	Н.Лхагваа “Дүүжин даажин”	Дүрслэлийн хэлбэр	Ж.Дашдондог “Дүүжин даажин”	Дүрслэлийн хэлбэр
1-р бадаг	Жингийн цагаан туухай шиг хоёр хөөрхөн охин Жинлүүрийн царан таваг шиг хормойгоо дэрвийлгэн Дүүжин даажин Дүүлэн наадна	Ерөнхий дүрс /ЕД/	Наашаа цаашаа Дүүжин даажин Хойшоо урагшаа Дүүжин даажин	жигд
2-р бадаг	Эмээлийн хоёр бүүрэг шиг ихэр юм шиг үзэгдэнэ Эрвээхэйн хоёр далавч шиг нисч бууж үзэгдэнэ дүүжин даажин Дүүлэн наадна	Дунд дүрс /ДД/	Ийшээ тийшээ Дүүжин даажин Дээшээ доошоо Дүүжин даажин	жигд
3-р бадаг	Тэнгэр газарт инээж Тэр хоёр баясна Тэртээх энэтээх уулс Тэргүүн дээгүүр нь өнгөлзөнө	Том дүрс /ТД/ Дүүжингийн голд зогсоод хоёр охиныг савлагаан дунд нь авч байна.	Дүүлэн нислээ Дүүжин даажин Үүлэнд хүрлээ Дүүжин даажин	жигд Гэхдээ дуран өөр өнцгөөс авч эхэлсэн учир сонирхолтой болж байна.
4-р бадаг	Бие биенээ дээдэлж Ээлж ээлжээр өргөнө Би чи гэлгүй Эе эвээр тоглоно	Дунд дүрс /ДД/	Тэнгэрт гарлаа Дүүжин даажин Тэгснээ буулаа Дүүжин даажин	

Нэг нь холдож ойртоод байгаа болохоор арай илүү сонирхолтой, нөгөө нь хэм хэмнэл сайтай боловч нэгэн хэвийн түвшинд дүрсэлсэн учраас тийм ч шинэ содон харагдахгүй байна. Хэм хэмнэлтэй шүлгээр хамгийн олон оролцогчдын санал авсан Н.Лхагваагийн “Дүүжин даажин” шүлгийн талаар “Үг, үг мөр шаадын хэмнэл сайтай”, “Охидын сайхан нөхөрлөлийг дүүжин даажингийн эн тэнцүү хэмнэлтэй холбосон”, “Тоглож байгаа нь нүдэнд тод харагдсан”, “Онож дүрсэлсэн” “Яг л хүүхэд болоод тоглож байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлж байна. Ертөнцийн баяр баясгаланг мэдрүүлж байна” /эмэгтэй оюутан/ гэх мэтээр онцолжээ.

Эндээс үзэхэд харагдах дүр дүрстэй шүлэгт хүүхдүүд илүү дуртай байгаа нь эргэлзээгүй. Төгсгөлд нь дүгнэж хэлэхэд “ҮЗЭГДЭХҮЙЦ БАЙХ” гэдэг хүүхдийн яруу

найргийн уран чадварын нэг хүчин зүйл мөн юм. Энэ чадварыг Монголын үе үеийн сайн яруу найрагчид бүтээлдээ тусгаж ирсэн нь нотлогдож байна.

НОМ ЗҮЙ

1. Аръяасүрэн. Ч (1980), *Орчин үеийн монголын хүүхдийн зохиол*, Улаанбаатар.,
2. Батжаргал. Д (2008), *Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар*, Улаанбаатар.,
3. Давааням.Д (2003), *“XX зууны монгол зохиолчид” цуврал*, Улаанбаатар.,
4. Дүрслэх урлагийн нэр томъёоны тайлбар толь www.read.mn цахим хуудас.,
5. Кузнецов. Г. В (2002), *Телевизионная журналистика*, Москва.,
6. Gerald Millerson (2004), *Television production*, BBC.,
7. “Монголын хүүхдийн уран зохиол” 1 боть, (2007), Улаанбаатар.,
8. Наранжаргал. Х (2007), *Телевизийн сэтгүүл зүй*, Улаанбаатар.,
9. Содномдорж. Д (2003), *XX зууны монгол зохиолчид*, 29 дүгээр тал, Улаанбаатар.,
10. Түдэв. Л (1998), “Түмэн хүүхдийн эчнээ багш” өгүүлэл. “Содномдорж түүний нөхөд” ном. Улаанбаатар.,
11. *Хүүхдийн зохиолын дээжис*. (1971), Улаанбаатар.,
12. *Хүүхдийн уран зохиолын дээж*, (1981), Улаанбаатар.,
13. Цэдэндорж. М (1984), *Уран зохиолын тухай бодол*, Улаанбаатар.,
14. Явуухулан. Б (1990), “1960-аад оны эхний хагасын манай үеийн яруу найраг” II боть, Улаанбаатар.,

SUMMARY

In terms of mastery, new requirement for vivid imagery arose in children's poetry. But research shows, poems which use shifting and agile imagery and style are more interesting.